


1. Зурагт үзүүлсэн бодис нь ямар төлөвтэй вэ?



A. шингэн


B. плазма

C. хий


D. хатуу

Анхаараарай !!!


Доорх өгөгдлийг ашиглан 2, 3, 4, 5, 6 - р асуултад хариулаарай.



1



2



3

2. Тасалгаанд байгаа дараах бодисуудаас жижиг хэсгийг нь дээрх зургийн 2 дугаартай бодисын загвараар илэрхийлэх боломжтой бодисыг нэрлэнэ үү.

A. жүүс

B. харандаа

C. ургамлын тос

D. хүжний утаа

3. Нэгэн бодис төлөвийн шилжилтэд орсон нь дээрх зургийн 3 дугаартайгаас 1 дугаартай руу шилжсэн гэж үзвэл энэ бодис ямар төлөвийн шилжилтэд орсон бэ?

A. конденсацлах

B. хайлах

C. цасжих

D. уурших

4. Дээрх зурагт дугаарласан гурван бодисын аль нь нягт ихтэй вэ?

A. 1

B. 2

C. 3

D. 2, 3

5. Дээрх зурагт дугаарласан гурван бодисын жижиг хэсгийн хөдөлгөөн багасах дараалалд оруулсан эгнээг сонгоорой. /2 оноо/

A. 2→3→1

B. 1→2→3

C. 1→3→2

D. 2→1→3

6. Өөрийн гэсэн хэлбэр дүрсгүй, жижиг хэсгүүд сул хүчээр таталцаж, хол зайтай байрлах ба эмх замбараагүй, хурдан шилжин хөдлөж байдаг гэсэн тодорхойлолт аль бодисыг нь тодорхойлж байна вэ?

A. 1

B. 2

C. 3

D. 1, 3

7. Зурагт ямар шинж чанартай материалыг үзүүлсэн байна вэ?



A. бат бэх

B. хэврэг

C. зөөлөн

D. тунгалаг

8. Доорх жишээнүүдээс аль нь металлыг цахилгаан дамжуулагч болгон харуулж байна вэ?

A.

B.

C.

D.



9. Цонхыг шилээр хийдэг. Ямар шинжийг нь ашиглаж байгаа вэ?

- A. гэрэл нэвтрүүлэх
C. бат бөх
B. металл биш
D. дулаан дамжуулдаг

10. Үсний боолтыг резинээр хийдэг нь ямар шинж чанарт үндэслэж байна вэ?

- A. дулаан дамжуулах
C. уян хатан
B. давтагдах
D. гялтганах

11. Доорх хүснэгтэд өгсөн мэдээллийг ашиглаад материалуудын дулаан дамжуулах чанарын өсөх дарааллаар нь байрлуулсан эгнээг сонгоно уу. /2 оноо/

Материал	Дулаан дамжуулах шинж (температур)
зэс	401.0
мод	0.08
алмаз	230.0
хуванцар (PVC)	0.019
мөнгө	427.0

- A. хуванцар < мод < мөнгө
C. хуванцар < мөнгө < мод
B. мөнгө < мод < хуванцар
D. мод < хуванцар < мөнгө

12. Дараах бодис, материалуудаас суурилаг шинж чанартайг нь сонгоорой .

- A. содын уусмал
B. кола
C. нимбэгний шүүс
D. уксус

13. Үл мэдэгдэх өнгөгүй уусмалд хөх лакмусын цаас дүржээ, хэсэг хугацааны дараа улаан өнгөтэй болжээ. Ямар уусмал байсан бэ?

- A. содын уусмал
C. савангийн уусмал
B. натрийн гидроксидын уусмал
D. нимбэгний хүчлийн уусмал

14. Савангийн уусмал дээр хүрэн байцайны индикатор дусаахад уусмал ямар өнгөтэй болох вэ?

- A. ягаан
B. шар
C. ногоон
D. улаан

15. Хүчлийн уусмалд метилоранжийн индикаторыг дусаав. Дараа нь түүн дээр суурийн уусмалаас нэмэхэд уусмалын өнгө хэрхэн өөрчлөгдөх вэ? Ямар үзэгдэл явагдсан бэ?

- A. улаанаас шар, уусах
C. өнгөгүйгээс ногоон, уусах
B. ягаанаас өнгөгүй, саармагжих
D. улаанаас шар, саармагжих

16. Химийн лабораторт бодисын шошго дээр аюулгүйн тэмдэг тавьсан байдаг.

Хүчил агуулсан савны гадна талд яагаад зурагт үзүүлсэн тэмдэг байрлуулсан бэ?



- A. хүчил нь дэгдэмхий
B. хүчил асгарч болзошгүй
C. хүчил нь арьс салстыг түлдэг учраас
D. хүчил исгэлэн амттай, лакмусд улаан өнгө үзүүлдэг.

17. Эдгээрийн аль нь хүчиллэг борооны шууд үр дагавар вэ?
- A. ойн түймэр
C. газар хагарах
B. цаг уурын өөрчлөлт
D. ургамлын ургалт зогсох
18. Усны бохирдолд хүний үзүүлэх нөлөө аль нь вэ?
- A. газар тариалан эрхлэх
C. голын эргээр мод тарих
B. голын усанд хувцас угаах
D. нийт талбайг зүлэгжүүлэх
19. Ихэнх ургамал ургахад таатай орчин бүрдүүлэхийн тулд ямар уусмалаар услах вэ?
- A. саармаг уусмал
C. хүчлийн уусмал
B. сул хүчиллэг уусмал
D. суурилаг уусмал
20. Усны бохирдлыг илэрхийлэх мэдээллийг олоорой.
- I. Химийн бодис асгарвал газрын гүний усыг бохирдуулдаг.
II. Дэлхийг гадаргын $\frac{2}{3}$ -г ус эзлэнэ.
III. Ус өвчин үүсгэгч 700 гаруй төрлийн вирус эгэл биетэн, мөөг мөөгөнцөрөөр бохирддог байна
- A. I, II
B. II, III
C. III, IV
D. I, III